4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,000.00	(2,000.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,000.00	(2,000.00)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	59.00	59.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	310.00	235.00	75.00	75.8

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	353,178,600.00	336,491,168.62	16,687,431.38	95.3
21	Урсгал зардлын дүн	353,178,600.00	336,491,168.62	16,687,431.38	95.3
210	Бараа, үйлчилгээний зардал	353,178,600.00	336,491,168.62	16,687,431.38	95.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,670,400.00	52,529,863.52	13,140,536.48	80.0
210101	Үндсэн цалин	65,670,400.00	40,891,428.60	24,778,971.40	62.3
210102	Нэмэгдэл	-	6,639,914.00	(6,639,914.00)	-
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	-	2,016,000.00	(2,016,000.00)	-
210104	Урамшуулал	-	2,982,520.92	(2,982,520.92)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,208,800.00	4,661,905.10	3,546,894.90	56.8
210201	Тэтгэврийн даатгал	5,582,000.00	3,207,657.91	2,374,342.09	57.5
210202	Тэтгэмжийн даатгал	656,800.00	377,371.58	279,428.42	57.5
210203	ҮОМШӨ ний даатгал	525,200.00	301,897.20	223,302.80	57.5
210204	Ажилгүйдлийн даатгал	131,200.00	70,452.59	60,747.41	53.7
210205	Эрүүл мэндийн даатгал	1,313,600.00	704,525.82	609,074.18	53.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,584,000.00	278,584,000.00	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	8,563,000.00	11,784,531.00	(3,221,531.00)	137.6
210302	Түлш, халаалт	258,371,000.00	253,797,550.00	4,573,450.00	98.2
210303	Цэвэр, бохир ус	11,650,000.00	13,001,919.00	(1,351,919.00)	111.6
2106	Эд хогшил худалдан авах	715,400.00	715,400.00	-	100.0
210604	Урсгал засвар	715,400.00	715,400.00	-	100.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	353,178,600.00	353,178,600.00	-	100.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	353,178,600.00	353,178,600.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	353,178,600.00	353,178,600.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	Ажиллагсдын тоо	59.00	59.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-	100.0
63	Суралцагчдын тоо /жилийн дунджаар/	310.00	235.00	75.00	75.8

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.8 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	6,944,600.00
21	Урсгал зардлын дүн	-	6,944,600.00
210	Бараа, үйлчилгээний зардал	-	6,944,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,721,600.00
210402	Тээвэр (шатахуун)	-	1,825,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	896,600.00
2105	Нормативт зардал	-	614,000.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	614,000.00
2106	Эд хогшил худалдан авах	-	3,069,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,069,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	540,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	540,000.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	6,944,600.00
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	6,944,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,944,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Төв аймаг дахь политехник коллеж нь “Салбартаа дэвшилтэт технологи, ур чадварыг эзэмшсэн чадварлаг ажиллах хүчнийг бэлтгэдэг “Сургалт-Дадлага-Үйлдвэрлэл” хосолсон магадлан итгэмжлэгдсэн сургууль болно.” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Төв аймаг дахь политехник коллежийн үйл эрх зүйн орчин нь Боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай: Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн. Техникийн боловсролын сургалтын байгууллагын хэв шинж нь политехник коллеж байна гэж заасантай нийцэж байна.

Төв аймаг дахь Политехник коллеж нь 2022 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяаллаас Боловсрол Шинжлэх Ухааны яаманд шилжсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 04 дүгээр сарын 2-ний өдөр батлагдсан./
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал” хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д” Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”
6. Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 122 дугаар тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ыг баталсан.
7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол
8. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам”-ыг батлах тухай Боловсрол

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал

9. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Байгууллагын дотоод хяналтын талаар

Байгууллагын Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нь 2022 онд нийт 9 зорилт 78 арга хэмжээг төлөвлөн сургалт, санхүү, эрсдэлийн үнэлгээ, бусад асуудлын талаар хяналт-шинжилгээ хийж тухай бүрд зөвлөмж өгч ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймаг дахь Баянчандмань сумын Политехник коллежийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймаг дахь политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,414.5 төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	-	-
Авлага	4,790.5	5,267.9	477.4
Бараа материал	94,448.0	96,412.6	1,964.6
Үндсэн хөрөнгө	2,523,137.5	2,571,110.0	47,972.5
Нийт хөрөнгийн дүн	2,622,378.1	2,672,792.6	50,414.5
Богино хугацаат өр төлбөр	3,259.6	31,638.7	28,379.1
Засгийн газрын хувь оролцоо	2,619,118.4	2,641,153.9	22,035.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,622,378.1	2,672,792.6	50,414.5

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Авлага дансны үлдэгдэл 477.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татвар, нийгмийн даатгалын программын алдаанаас шалтгаалсан байна.
2. Бараа материалын дансны үлдэгдэл 1,964.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 157,320.9 мянган төгрөгийн орлого, 155,357.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэнтэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 47,972.5 мянган төгрөгөөр нэмэгдэхэд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнэлгээг шинэчлэн тогтоосноос шалтгаалсан байна.
4. Богино хугацаат өр төлбөрийн данс 31,638.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс халаалтын үнийг нэмж, Орон нутгийн төсвөөс үнэ нэмсэнтэй холбоотой тодотгол хийгээгүйгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,779,265.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,779,265.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 188,697.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,590,567.8 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь Төв аймаг дахь политехник коллежийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,590,567.8 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,269,981.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 353,178.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 6,944.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,542,748.7 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 56,119.0 мянган төгрөгөөр, нийтлэг үйлчилгээний зардлыг 16,687.4 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээний зардлыг 6,789.8 мянган төгрөгөөр ажил олгох тэтгэмжийг 100.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,179,493.7	1,123,374.7	56,119.0	95.24%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	30,490.2	30,390.2	100.0	99.67%
3	81806-Дотуур байрны үйлчилгээ	59,997.8	53,208.0	6,789.8	88.68%
Дүн		1,269,981.7	1,206,972.9	63,008.8	95.04%
	Орон нутгийн төсвөөс				
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	278,584.0	278,584.0	-	100.00%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	74,594.6	57,907.2	16,687.4	77.63%
Дүн		353,178.6	335,775.8	16,687.4	95.07%
Нийт дүн		1,623,160.3	1,542,748.7	79,696.2	95.05%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 6,944.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Хангамж, бараа материалын зардалд 2,721.6 мянган төгрөг, норматив зардалд 614.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авахад 3,069.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 540.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймаг дахь политехник коллежийнд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймаг дахь политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг дахь политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлын 1 хувиар буюу 17,709.2 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,396.4 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 133 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 20 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 удаагийн 285,105.6 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 231,948.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 5 удаагийн 20,969.9 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Дотоод хяналтын талаар:

Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дотоод аудитын бүрэлдэхүүнийг сайжруулах, холбогдох заавар аргачлалаар хангаж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймаг дахь политехник коллежийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг Уваа-Уул Аудит ХХК гүйцэтгэж, нийт 230.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	230.0	4	230.0	100
Нийт дүн	4	230.0	4	230.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

**Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хандив тусламжаар авсан тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,623,446.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг, аудитын явцад бүрэн залруулсан.

- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 1,068.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулсан байна.
- Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 2,622,378.1 мянган төгрөгийг залруулсан.

Аудитаар нийт 25,767.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 913.6 мянган төгрөгийн зөвлөмж, 29.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 24,825.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Арилжааны банк дахь дансны талаар:

Хаан банканд 2.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 5721508521 тоот харилцах данстай байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-т “Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

Хоол, унааны хөнгөлөлтийн талаар:

Нийт 17 ажилтныг томилолтоор ажиллуулах үед хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод 574.0 мянган төгрөгийн хоолны олговрыг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Төлбөрийн баримттай холбоотой:

Илрүүлэлт:

Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 15 иргэн, байгууллага 5,576.1 мянган төгрөгөөр илүү, 2 иргэн байгууллага 607.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Төв аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төлбөрийн баримтын системд зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл***/Мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 1,068.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулсан байна.	1	1,068.0	-	-	1	1,068.0	1	1,068.0	-	-	-	-
Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 2,622,378.1 мянган төгрөгийг	1	2,622,378.1	1	2,622,378.1			1	2,622,378.1				
Дүн	1	2,623,446.1	1	2,622,378.1	1	1,068.0	1	2,623,446.1	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хаан банканд 2.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 5721508521 тоот харилцах данстай байна.	1	2.0	1	2.0	-	-	-	-	-	-	-	-
Нийт 17 ажилтныг томилолтоор ажиллуулах үед хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод 574.0 мянган төгрөгийн хоолны олговрыг давхардуулан олгосон байна.	1	574.0	1	574.0	-	-	-	-	-	-	-	-
Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 15 иргэн, байгууллага 5,576.1 мянган төгрөгөөр илүү, 2 иргэн байгууллага 607.0 төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.	1	6,183.1	-	-	-	-	1	6,183.1	-	-	-	-
Дүн	3	6,759.1	2	576.0	-	-	1	6,183.1	-	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 133 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 20 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 удаагийн 285,105.6 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 231,948.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 5 удаагийн 20,969.9 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.	1	538,023.9	-	-	-	-	1	538,023.9
Дүн	1	538,023.9	-	-	-	-	1	538,023.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	2	538,023.9	-	-	-	-	2	538,023.9